

**“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 11 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төс өв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/	Үнэлгээ (хувь)
				Он	Түвшин			
1	2	3	4	5	6	7	8	9
Зорилт 2.7.Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.								
2.7.3.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	0.0	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2023	Шинэчлэн хөгжүүлэх программ хангамжийн тоо-1	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	Монгол Улсад 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 32194 хувийн хэргээр оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн, харьяалалгүй хүн үүнээс хамгийн их буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 18254 иргэн Монгол Улсад бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна. Түүнчлэн 1779 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1220 иргэн Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс мөн хэтрээгүй байна. “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг нэвтрүүлэх арга хэмжээг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад оруулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг уг системтэй 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс холбон үйлчилгээ үзүүлж эхэлсэн. “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системд нийт 636 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан тайлант хугацаанд	100

1	2	3	4	5	6	7	8	9
							<p>визийн зөвшөөрөл, виз олголт, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, гадаадын иргэний хаягийн бүртгэл, гадаадын иргэний 48 цагийн бүртгэлтэй холбоотой 47174 хүсэлтийг хүлээн авч, тус тус хянан шийдвэрлэлээ.</p> <p>Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт" төслийн хүрээнд байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн.</p> <p>Системийн хөгжүүлэлтэд 2024 онд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.</p>	
Үнэлгээ 100 хувь								

--oo0oo--